

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО БА ХҮНД ЭЭЛТЭЙ АМЬДРАХ ОРЧНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

*ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн багш
Н.Хүсэл.*

Хураангуй. Сүүлийн үед Олон улсад Хүний хөгжлийн үндсэн хэмжүүрийг чанартай амьдрал гэж үзэх хандлага ажиглагдах болсон. Чанартай амьдралын үзүүлэлт гэдэг нь хүн эрүүл байж, өөрийн авьяас чадвар, чадамжаа нээн илрүүлэх, түүнийгээ хөгжүүлэх, үр шимийг нь хүртэх боломж нөхцөлийг бий болгох ойлголт юм. Эдгээр ойлголт судлагдаж байгаа өнөө цагт хүний эрүүл байхын гол үндэс суурь нь хүрээлэн буй орчин буюу эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах баталгаа гэж үзэж байна. Тиймээс Монгол Улсын нийт хүн амын амьдралын сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд анхаарах, байгалийн нөөц баялгаа зохистойгоор ашиглах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд иргэд олон нийтийн байгууллагын хамтын ажиллагаа хэрхэн хэрэгжиж байгаад шинжилгээ хийж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл явцад тулгамдсан асуудлыг тодорхойлохыг зорилоо.

Түлхүүр үг: тогтвортой хөгжил, эрүүл орчин, хөтөлбөр

Нэгдсэн үндэсний байгууллагын Ерөнхий Ассамблейн Тогтвортой хөгжлийн дээд хэмжээний 2015 оны 9 дүгээр сард зохион байгуулагдсан чуулга уулзалтаар 17 зорилго, 169 зорилт, 244 шалгуур үзүүлэлт бүхий 2030 он хүртэлх Дэлхийн Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг баталсан нь тогтвортой хөгжлийг зайлшгүй бодлогын түвшинд хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага байгааг олж харж, дэлхий нийтийн түвшинд зорилтуудыг гаргасан бөгөөд улс орон бүр эдгээр зорилтуудыг үндэсний хөгжлийн төлөвлөлтийн үйл явц, бодлого, стратегитай уялдуулах ажлыг хэдийн эхэлсэн нь манай улс оронд хэрэгжиж байгаагаас харж болно. 2016 оны 1 сарын 1-нээс “Тогтвортой хөгжлийн зорилго” албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн ба энэ нь **нийгэм, эдийн засаг, байгаль орчин** гэсэн хөгжлийн тулгуурт суурилан тогтвортой хөгжилд хүрэх Дэлхийн нийтийн урт хугацааны бодлогын баримт бичиг юм.

Манай орны хувьд “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого нь суурь есөн зорилго, 47 зорилттой бөгөөд 2021-2030 он, 2031-2040 он, 2041-2050 он гэсэн 3 үе шаттайгаар зорилт тус бүрийн хүрэх үр дүнг тодорхойлсон ба эдгээр зорилтын хэрэгжилтийг үнэлэх 73 шалгуур үзүүлэлттэйгээр боловсруулж батлагдсан байна. Түүнчлэн Улсын Их Хурлаас Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурал 2020 оны 05 дугаар сарын 07-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан бөгөөд Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой, залгамж чанарыг хангах, үндэсний хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчмыг тодорхойлж, Монгол Улс 30 жилийн хугацаанд хэрэгжүүлэх урт хугацааны хөгжлийн нэг бодлоготой байхаар тусгасан нь дэлхийн хөгжингүй улс орнуудаас жишиг авч, тэдгээр орнуудаас хөгжлийн хувьд хоцрохгүй байх бодлого, баримт бичиг боловсруулах шаардлага тулгарснаар Монгол Улсын Их хурлаас гаргасан урт хугацааны хөгжлийн бодлого, Алсын хараа-2050 зорилго, зорилтыг гаргаж

энэхүү бодлогыг хэрэгжүүлээд цөөн хэдэн жилийг үдэж байгаатай холбогдуулан урт хугацааны бодлогын хэрэгжилтийг судлах хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

Монгол Улсын эрх зүйн зохицуулалт:

Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй ба Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй мөн хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн.⁸

Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.⁹

Хуулиар хамгаалах объект, түүнтэй холбогдсон нэр томъёо:

- ✓ "байгаль орчин" гэдэгт хүний амьдрал, үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлдөг Монгол Улсын нутаг дэвсгэрийн чулуун мандал, усан мандал, шим мандал, агаар мандлын харилцан шүтэлцээт хүрээлэл хамаарна;
- ✓ "ус" гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэр дэх мөрөн, гол, горхи, булаг, шанд, рашаан, мөнх цас, мөс, мөсөн гол, байгалийн болон хиймэл нуур, цөөрөм зэрэг газрын гадаргын болон газрын доорх ус хамаарна;
- ✓ "ургамал" гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт ургадаг байгалийн болон таримал ой, мод, бүх төрлийн дээд, доод ургамал хамаарна;
- ✓ "агаар" гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрийн хийн бүрхэвч хамаарна;
- ✓ "байгаль орчинд хортой нөлөөлөх" гэдэгт байгаль орчин, түүний баялгийг бохирдуулах, муутгах, гэмтээх, сүйтгэх, сөнөөж мөхөөх үйлдэл / эс үйлдэхүй/ хамаарна.
- ✓ "байгаль орчныг хамгаалах" гэдэгт байгаль орчныг бохирдохоос урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг нь алдагдуулахгүйгээр, байгалийн даацад нь тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавих ажиллагаа хамаарна;
- ✓ "байгаль орчинд учруулсан хохирол" гэж байгалийн баялгийг зөвшөөрөлгүй бэлтгэсэн, олборлосон, эсхүл байгаль орчны чадавхын тогтоосон хэм хэмжээ, зөвшөөрөгдөх дээд хэмжээний хязгаараас хэтрүүлэн байгаль орчныг бохирдуулсан, доройтуулсан, гэмтээсэн, байгалийн нөөц баялгийг хомсдуулсан, экологийн тогтолцоог алдагдуулсан аливаа үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

⁸ Монгол Улсын үндсэн хууль

⁹ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 1 дүгээр зүйл

Байгаль орчныг хамгаалах талаархи иргэний эрх, үүрэг¹⁰

Байгаль орчныг хамгаалах олон нийтийн байгууллага байгуулах, хөрөнгийн сан үүсгэх нутгийн иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгалийн баялгийг арчлан хамгаалах, нөхөн сэргээх, түүний ашиг шимийг хүртэх, байгалийн нөөц, баялгийн халдашгүй байдлыг хангах, байгаль орчинд хортой нөлөөлөх аливаа үйл ажиллагааг хязгаарлах, таслан зогсоох шийдвэр гаргахыг болон байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй аж ахуйн нэгж, байгууллагыг шинээр байгуулах зөвшөөрөл олгохгүй байхыг холбогдох эрх бүхий байгууллагаас шаардана.

Иргэн байгаль орчныг хамгаалах талаар дараахь үүрэг хүлээнэ:

Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх, үндэсний уламжлал, зан заншил эзэмшиж хэрэглэх, үр хүүхдэдээ экологийн хүмүүжил олгох, байгаль орчинд хортой нөлөөлөхөөс сэргийлэх, өөрийн буруугаас учруулсан хортой нөлөөлөл, түүний хохирлыг арилгах буюу нөхөн төлнө.

Байгаль орчныг хамгаалах талаарх төрийн чиг үүрэг, зарчим¹¹

Төр нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор байгаль орчинд хортой нөлөөлөхөөс болон байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлэн хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлж хүний амьдрах, хөдөлмөрлөх, амрах байгаль орчны тааламжтай нөхцөл бүрдүүлэх, экологийн баримжаатай эдийн засгийг хөгжүүлж байгаль орчны тэнцлийг хангах, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг ашиглах шийдвэр, үйл ажиллагаа ил тод байна.

Байгаль орчны судалгаа, шинжилгээ, түүний санхүүжилт¹²

Улсын болон бүс нутгийн хөгжлийн баримжааг тодорхойлох, нэн ховордсон амьтан, ургамлыг нөхөн сэргээх, өсгөн үржүүлэх, хөрс, ус, агаарыг хамгаалах болон хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах талаарх судалгаа, шинжилгээний ажлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

Байгаль орчныг хамгаалах талаарх төрийн байгууллагын бүрэн эрх¹³

Улсын Их Хурал байгаль орчныг хамгаалах талаар байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх төрийн бодлогыг тодорхойлох, Засгийн газрын өргөн мэдүүлснээр байгаль орчныг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр батлах, байгалийн баялгийн нөөцийг ашигласны болон орчныг бохирдуулсны төлбөр, хураамжийн дээд, доод хэмжээг тогтоох, устах аюулд орсон амьтан, ургамлын жагсаалтыг батлах, өөрчлөх, байгалийн зарим объектыг улсын тусгай хамгаалалтад авах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Засгийн газар байгаль орчныг хамгаалах¹⁴ экологийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, байгалийн баялгийг ашиглах, импортлох, экспортлох хэмжээг хуульд заасан үндэслэлээр хязгаарлах буюу тодорхой хугацаагаар хориглох, иргэдэд экологийн боловсрол, хүмүүжил олгох ажлыг зохион байгуулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх¹⁵

¹⁰ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйл

¹¹ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйл

¹² Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 11 дугаар зүйл

¹³ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйл

¹⁴ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйл

¹⁵ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйл

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны тэнцлийг хангах, байгаль орчинд учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгуулах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, салбар дундын болон бүс нутаг хоорондын удирдлага, бодлогын төлөвлөлт, зохицуулалтыг хариуцаж, байгаль орчны чадавхын хэм хэмжээ, стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах буюу төрийн захиргааны холбогдох төв байгууллагатай хамтран баталж, биелэлтийг зохион байгуулах, экологи-эдийн засгийн үнэлгээ тооцох аргачлалыг батална.

Байгаль орчныг хамгаалах талаар улсын захиалга өгч судалгаа, шинжилгээ, зураг төслийн ажил гүйцэтгүүлэх, өөрийн харьяа судалгаа, шинжилгээ, зураг төслийн болон мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг удирдах, байгаль орчны тухай мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангах биологийн болон генетикийн нөөцийг тогтвортой ашиглахад чиглэгдсэн уламжлалт мэдлэг, шинэ санаа, амьдралын туршлагыг хэрэглэснээр гарах үр ашгийг тэгш, шударгаар ашиглах явдлыг дэмжих, байгаль орчныг хамгаалах асуудлаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх, экологийн боловсрол, хүмүүжил олгох ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Байгаль орчныг хамгаалах нийтлэг арга хэлбэр¹⁶

Монгол Улс санхүүгийн баталгаа бүхий "Байгаль орчныг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр"- тэй байна. Нийт хүн амд экологийн боловсрол, хүмүүжил олгох, үндэсний өв уламжлалыг эзэмшүүлэх хоргүй, аюулгүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи нэвтрүүлэн ашиглахыг урамшуулна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал¹⁷

“Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа” гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалан бэхжүүлэх тал бүрийн баталгаа бий болгоход чиглэсэн төрийн бодлогын байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнээс хэрэгжүүлж буй арга хэмжээг хэлэх ба Экологийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог зааж өгсөн.

Хөгжлийн бодлого, хөтөлбөр

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн ““Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурал 2020 оны 05 дугаар сарын 13-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан ба уг тогтоолын хавсралтад Монгол Улс 2050 он хүртэл хугацаанд хэрэгжүүлэх урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилт, хүрэх үр дүн, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хяналт шинжилгээ-үнэлгээний шалгуур үзүүлэлтийг

¹⁶ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 19 дугаар зүйл

¹⁷ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 3 дугаар зүйл

тодорхойлж өгсөн. Үүнээс авч үзэхэд урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэхэд зөвхөн манай улс гэлтгүй аливаа улс орон салбар бүрийн оролцоотойгоор хэрэгжүүлэх шаардлагатай гэдгийг анхаарах нь зүйтэй юм.

Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдсанаар Монгол Улс ирэх 30 жилийн хугацаанд 3 үе шаттайгаар Үндэсний нэгдмэл үнэт зүйл, Хүний хөгжил, Амьдралын чанар ба дундаж давхарга, Эдийн засаг, Засаглал, Ногоон хөгжил, Амар тайван аюулгүй нийгэм, Бүс, орон нутгийн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот гэсэн 9 зорилгын хүрээнд 47 зорилтыг дэвшүүлж, үе шат бүрд хүрэх үр дүнг тодорхойлон, хэрэгжүүлэхээр тусгасан.¹⁸

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын үнэт зүйл, зорилго чиглэл нь Монгол хүний амьдралын сайн сайхан байдлыг дээшлүүлэх, Монгол Улс 2050 онд нийгэм, эдийн засгийн хөгжил, амьдралын чанараар Ази тивд тэргүүлэгч орнуудын нэг болох, төрт ёс, өв соёл, үндэс язгуураа дээдлэх, хүн төрөлхтний дэвшилтэт ололтод хөл нийлүүлэн алхах, хүрээлэн буй орчин, байгаль, дэлхийгээ хайрлан хамгаалах, ардчилсан шударга засаглалыг бэхжүүлэх, аливаа улс орноос эдийн засгийн хараат бус байх эрхэм зорилгыг агуулсан бодлогын баримт бичиг батлагдсан юм. Тус урт хугацааны хөгжлийн бодлогыг батлахдаа Улсын Их Хурлаас 2016 онд баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтуудыг агуулгаар нь “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 1 дүгээр үе шат буюу 2030 он хүртэлх хугацааны хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд бүрэн тусгасан ба зарим үр дүнг дахин шинэчлэн тусгасан байна.

Дэлхий нийтээрээ хүрэхээр зорьж буй Тогтвортой хөгжлийн зорилтын 11 дүгээр зорилго бол “Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих” юм. Энэ хүрээнд 2030 он гэхэд дараах зорилтуудыг биелүүлсэн байхаар зорьж байна.

Үүнд:

- Хүрэлцэхүйц, аюулгүй, хямд үнэтэй орон сууц, суурь үйлчилгээгээр хүн бүрийг хангаж, орлого багатай иргэдийн хорооллыг сайжруулах
- Эмзэг бүлгийн хүн ам, эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг онцгой анхааран, замын аюулгүй байдал, тухайлбал нийтийн тээврийг өргөжүүлэн сайжруулах замаар аюулгүй, хямд үнэтэй, хүртээмжтэй, тогтвортой тээврийн системийг хүн бүрд хүргэх
- Агаарын чанар, хотын болон хог хаягдлын менежментийн асуудалд онцгой анхаарлаа хандуулах замаар хотуудын нэг хүнд ногдох байгаль орчныг сөрөг нөлөөллийг бууруулах
- Хүн бүрийг, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настнууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аюулгүй, бүх талын оролцоог хангасан, хүртээмжтэй, ногоон болон нийтийн эзэмшлийн талбайгаар хангах
- Хамтын оролцооны, нэгдсэн, тогтвортой хүн амын суурьшлын төлөвлөлт, менежментийн чадавх, бүх талын оролцоог хангасан, тогтвортой хот байгуулалтыг сайжруулах юм.

Урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшний хөгжлийн бодлого, баримт бичигт тусгаж, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэх үүргийг Монгол Улсын Засгийн газарт өгсөн ба “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод таван жил тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үндэслэн дараагийн үе шатанд

¹⁸“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого

хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн үе шатны хүрэх үр дүнтэй нь нийцүүлэн боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулж байхаар заажээ.

Манай улсын хувьд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгагдсан хүрээлэн буй орчны аюулгүй байдал хурцаар тавигдаж буй асуудлын нэг бол болж байна. Улаанбаатар хот агаарын бохирдлын хэмжээгээр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан агаарын чанарын зөвлөмжид зааснаас 20 дахин их үзүүлэлтэй гарч дэлхийд дээгүүр бичигдэж байгаа нь бидний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэд харшлах нөлөө үзүүлж байгааг илтгэн харуулж байна. Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй, хүртээмжтэй хот, орчныг бий болгох нь нийгмийн бусад бүлгүүд ч энэхүү хүртээмжтэй орчны ашиг тусыг хүртэж байдаг гэсэн ойлголт юм.

Дүгнэлт

Дэлхийд аз жаргалын индексийг амьдралын чанар, эерэг болон сөрөг сэтгэл хөдлөлийн үзүүлэлтэд тулгуурлан гаргадаг ба амьдралын чанар гэдэг нь өдөр тутам эрүүл, тогтвортой амьдрах суурь хэрэгцээ хангагдсан байдлыг хэлдэг ажээ. Монгол Улс аз жаргалын үзүүлэлтээр 5.76 оноогоор дэлхийн 149 улсаас 68 дугаарт эрэмбэлэгдэж байна. Үүнээс үзэхэд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудлын нэг бол Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага болох Байгаль орчныг хамгаалах алба, Гаалийн алба, Дипломат алба, Гамшгаас хамгаалах албадын салбар хоорондын хамтын ажиллагаа юм. Салбар хоорондын хамтын ажиллагаа дутмаг байгаагаас эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх эс хангагдаж, иргэд олон нийтийн эрх ашиг хөндөгдөж байна. Салбар тус бүрийн хууль, үзэл баримтлалд урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ гэж ерөнхий байдлаар тусгасан нь хэрэгжих явц, үр нөлөөнд дутагдалтай харагдаж байна.

Харин “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтод тус бүрийн чиглэлийг нарийвчлан тусгасан нь нийгмийн аль ч салбар, бүлэг, хүрээнд ойлгомжтой, хүртээмж сайтай байна гэж үзэж байна. Иймээс иргэд, олон нийтэд хөгжлийн бодлого, хөтөлбөрийг таниулах, сурталчлах, мэдээлэх цаашлаад Үндэсний хэмжээнд авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа болгон хэрхэн хэрэгжүүлэх талаар төрийн байгууллага, нийгмийн байгууламжид заавар зөвлөгөө гаргаж, арга замыг тодорхойлж өгөх шаардлага тулгарсан гэж дүгнэж байна.

Санал

Монгол Улс урт хугацааны хөгжлийн бодлого хөтөлбөрт тусгагдсан “Ээлтэй хот-иргэдийн оролцоог” дэмжих зохицуулалтад шинжилгээ хийж дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилт тус бүрийг таниулах, суртал ухуулга бүхий үндэсний хэмжээний аяныг сар бүр зохион байгуулах,
2. Ногоон хөгжил, эко орчныг төвлөрүүлэхэд иргэд, олон нийтийн байгууллагад хандив, тусламж, урамшуулал олгуулах,

Хөгжлийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлснээр аливаа улсад эдийн засгийн тогтворжилт, орлогын тэгш байдал хангагдаж дундаж давхаргыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Ашигласан эх сурвалж

Хууль, тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Байгаль, орчныг хамгаалах тухай хууль
3. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

УИХ, ЗГ-ын тогтоол, бодлогын баримт бичиг

1. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030
2. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого

Цахим эх сурвалж

1. <http://www.zasag.mn/>
2. <https://cabinet.gov.mn/>
3. <http://nda.gov.mn/>